



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 11 сарын 27 өдөр

Дугаар А/613

Мөрөн сум

Газар эзэмших эрхийн гэрчилгээ
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.1, 66 дугаар зүйлийн 66.1 Газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1, 37 дугаар зүйлийн 37.1, 37.2, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2, 38.4, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.2, 43 дугаар зүйлийн 43.1, Газрын харилцаа, геодези зураг зүйн газрын даргын 2021 оны А/187 дугаар тушаал, 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн А/133 дугаар тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Газар эзэмших эрхийн гэрчилгээгээ бусдад шилжүүлэх хүсэлт гаргасан 1 иргэн, 2 аж ахуйн нэгж байгууллагын нийт 0.6037 га (6037 м²) газрыг хавсралтаар тус тус шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Уг захирамжаар газар эзэмшиж байгаа иргэдтэй газар эзэмших эрх зүйн баталгаажилт хийж, Улсын бүртгэлд бүртгэхийг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг), Улсын бүртгэлийн хэлтсийн дарга (Б.Мөнгөнзул)-т тус тус зөвшөөрсүгэй.

3. Захиргааны актыг ажлын 5 хоногийн дотор эрх, ашиг сонирхол хөндөгдөж буй этгээдэд мэдэгдэж, баримтжуулсан захиргааны актыг хувийн хэрэгт бүрдүүлэлт хийж ажиллахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга (Б.Ганзориг)-т үүрэг болгосугай.

4. Наймгийн Засаг даргын захирамжийг эс зөвшөөрвөл захирамжийг мэдэгдсэнээс хойш 30 хоногийн дотор аймгийн Засаг даргад гомдол гаргах эрхтэй болохыг дурдсугай.

5. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хууль, эрх зүйн хэлтсийн дарга (Р.Машбат)-д үүрэг болгосугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ.

ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙН ГЭРЧИЛГЭЭГ БУСДАД ШИЛЖҮҮЛСЭН ИРГЭН, АЖ АХУЙН НЭГЖИЙН ЖАГСААЛТ



Аймгийн Засаг даргын 2023 оны
11 дүгээр сарын 27-ны өдрийн
А/613 дүгээр захирамжийн хавсралт

№	Эрх шилжүүлж байгаа иргэн, аж ахуйн нэгжийн овог, нэр, регистр	Эрх шилжүүлэн авч байгаа иргэн, аж ахуйн нэгжийн овог, нэр, регистр	Нэгж талбарын дугаар	Газрын зориулалт	Газрын байршил, хаяг	Газрын хэмжээ /м2/	Газар эзэмшүүлэх хугацаа	Хүчингүй болгож буй захирамжийн дугаар	Тайлбар
1	Боржигон овгийн Түмэнжаргал Одонтунгалаг (АГ86041328)	Зүүн хариад овгийн Өжтөө Төмөр (РУ78021111)	6712016312	Аминь орон сууц	13-р баг Шинэ мөрөн хороолол №31 тоот	182	12	Аймгийн Засаг даргын 2021.02.22-ны өдрийн А/101 дүгээр захирамжийн хавсралтын 5 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
2	"Мон-Ор" ХХК (РД:2614235)	Борнууд овгийн Тогтохбаяр Мижиддорж (РУ87021013)	6712017758	Худалдаа, нийтийн үйлчилгээний газар	7-р баг Хийморь-1 106 тоот	3250	7	Аймгийн Засаг даргын 2015.06.11-ний өдрийн А/226 дугаар захирамжийн холбогдох хэсэг	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр
3	"Хөвсгөл зам" ХХК (РД:2034719)	"Осбино" ХХК (РД:4129849)	6712008751	Албан контор	8-р баг Даваадорж-2 215 тоот	2605	20	Аймгийн Засаг даргын 2016.07.05-ны өдрийн А/343 дугаар захирамжийн хавсралтын 5 дахь заалт	Газар эзэмших эрх шилжүүлэх гэрээгээр

Нийт газрын хэмжээ: 6037 м²

[Handwritten signature]

000